

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/12/-НА-СТА-ТШЗ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА 417 ДУГААР
НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

᠒᠐᠒4.᠐᠒.᠒᠒ № ᠐1/᠒᠒

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оныг “Эрүү, иргэний, захиргаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд мэргэжлийн манлайлал, технологийн дэвшил, цахим шилжилтэд тулгуурлан нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглүүлэн үр дүнтэй зохион байгуулах” зорилго дэвшүүлэн 4 зорилт, 39 ажил, арга хэмжээг төлөвлөн 1,628,923.0 мянган төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаагаа явуулсан байна.

Аудитын гол асуудал

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 19 албан хаагчдад 357,521.4 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 13,315.2 мянган төгрөгийн төхөөрөмж, бараа материал худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай,

᠒19᠐᠒᠐᠐᠖1

зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	167,675,578.6	324,192,832.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,135,459.2	15,538,479.2
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,135,459.2	15,538,479.2
3121	Төгрөг	11,135,459.2	15,538,479.2
31211	Төрийн сангийн харилцах	11,135,459.2	15,538,479.2
33	АВЛАГА	4,460,948.0	13,348,446.2
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	44,012.2	0.0
335	Бусад авлага	4,416,935.8	13,348,446.2
3351	Байгууллагаас авах авлага	4,416,935.8	13,348,446.2
35	БАРАА МАТЕРИАЛ	152,079,171.4	295,305,907.5
351	Түүхий эд материал	45,359,662.8	48,716,928.3
35110	Тусгай зориулалттай материал	42,367,518.6	45,279,577.6
35130	Эм боох материал	2,992,144.2	3,437,350.7
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	0.0	15,000,000.0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	18,543,548.6	6,384,829.5
354	Хангамжийн материал	41,229,960.1	225,204,149.7
35410	Бичиг хэргийн материал	8,259,920.2	1,821,400.0
35420	Аж ахуйн материал	16,796,495.0	13,132,375.0
35440	Түлш, шатах тослох материал	2,321,500.0	790,084.5
35450	Барилгын засварын материал	2,567,607.4	1,812,607.4
35460	Хүнсний материал	6,982,887.5	26,159,937.8
35470	Бусад хангамжийн материал	4,301,550.0	3,417,745.0
35600	Мал амьтад	46,946,000.0	178,070,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,309,425,127.8	1,211,715,794.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,309,425,127.8	1,211,715,794.2
392	Биет хөрөнгө	901,636,887.8	803,927,554.2
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,047,190,289.7	1,047,190,289.7
39202	Хуримтлагдсан элэгдэл	-317,163,277.0	-402,950,917.8
39203	Авто-тээврийн хэрэгсэл	180,534,400.0	180,534,400.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-167,389,399.8	-175,034,399.8
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	245,871,969.4	276,847,719.4
39206	Хуримтлагдсан элэгдэл	-119,475,205.4	-152,314,371.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,324,345.5	19,324,345.5
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,164,234.7	-11,577,511.0
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	21,908,000.0	21,908,000.0
393	Биет бус хөрөнгө	407,788,240.0	407,788,240.0
39301	Програм хангамж	4,987,692.3	4,987,692.3
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,987,692.3	-4,987,692.3
39303	Бусад биет бус хөрөнгө	407,788,240.0	407,788,240.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,477,100,706.3	1,535,908,627.2

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	43,406,635.2	43,084,655.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,406,635.2	43,084,655.2
413	Өглөг	43,406,635.2	43,084,655.2
4136	Бусад өглөг	43,406,635.2	43,084,655.2
41361	Байгууллагад төлөх өглөг	27,912,100.0	23,187,100.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	15,494,535.2	19,897,555.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,433,694,071.1	1,492,823,972.0
51	Засгийн газрын хувь оролцоо	1,433,694,071.1	1,492,823,972.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	535,534,497.9	535,534,497.9
51101	Өмч: - төрийн	535,534,497.9	535,534,497.9
512	Хуримтлагдсан үр дүн	157,890,911.5	217,020,812.3
51210	Өмнөх үеийн үр дүн	199,762,782.5	157,806,832.4
51220	Тайлант үеийн үр дүн	-41,871,871.0	59,213,979.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	740,268,661.8	740,268,661.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,477,100,706.3	1,535,908,627.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	982,086,751.1	1,898,128,147.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	188,198,251.1	268,205,147.5
120	Нийтлэг татварын бус орлого	188,198,251.1	268,205,147.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	188,198,251.1	268,205,147.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,951,184.4	47,783,919.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	153,247,066.6	220,421,228.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	793,888,500.0	1,629,923,000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	793,888,500.0	1,628,923,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	793,888,500.0	1,628,923,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	1,000,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	1,000,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,023,958,622.1	1,838,914,167.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,023,958,622.1	1,838,914,167.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,014,902,941.3	1,379,143,068.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,318,403.1	882,760,175.9
210101	Үндсэн цалин	378,297,050.9	534,689,054.9
210102	Нэмэгдэл	198,939,658.4	288,466,125.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	25,212,765.2
210104	Урамшуулал	6,081,693.8	34,392,230.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,258,033.4	16,810,085.1
210205	Эрүүл мэндийн даатгал	11,258,033.4	16,810,085.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,869,554.4	91,180,737.9
210301	Гэрэл, цахилгаан	59,251,068.4	83,376,737.9
210302	Түлш, халаалт	14,548,486.0	6,804,000.0
210303	Цэвэр, бохир ус	1,070,000.0	1,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	28,298,889.3	60,500,608.3
210401	Бичиг хэрэг	1,832,150.0	10,004,320.2
210402	Тээвэр, шатахуун	17,480,000.0	29,212,545.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,236,961.8	653,112.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,500.0	33,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	684,296.0	11,069,410.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,838,421.5	1,188,719.8
210408	Бараа материал акталсны зардал	5,193,560.0	8,339,000.0
2105	Нормативт зардал	161,583,279.8	180,064,964.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,965,770.0	8,523,688.5
210502	Хоол, хүнс	123,208,806.7	145,563,392.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,408,703.1	25,977,883.8

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,461,720.0	4,640,160.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	67,320.0	198,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	93,800.0	0.0
210604	Урсгал засвар	6,300,600.0	4,442,160.0
2107	Томилолт, зочны зардал	180,000.0	0.0
210702	Дотоод албан томилолт	180,000.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,336,410.6	10,572,141.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,559,010.6	4,303,541.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	252,100.0	1,008,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	715,200.0	300,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	129,500.0	80,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500.0	4,554,500.0
210807	Газрын төлбөр	126,100.0	326,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,596,650.7	132,614,195.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,044,055.3	3,905,512.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,000.0	23,600.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,432,595.4	128,685,083.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,055,680.8	459,771,099.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,976,903.0	424,057,083.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	63,950,700.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	357,521,383.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,976,903.0	2,585,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,078,777.8	5,714,016.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,078,777.8	5,714,016.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,000,000.0	30,000,000.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,000.0	30,000,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-41,871,871.0	59,213,979.9
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-41,871,871.0	59,213,979.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	951,600,676.7	1,848,265,008.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	159,790,954.4	218,342,008.8
120	Нийтлэг татварын бус орлого	159,790,954.4	218,342,008.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	159,790,954.4	218,342,008.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	159,790,954.4	218,342,008.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	791,809,722.2	1,629,923,000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	791,809,722.2	1,628,923,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	791,809,722.2	1,628,923,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	1,000,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	1,000,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	946,054,469.7	1,830,629,988.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	946,054,469.7	1,830,629,988.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	939,077,566.7	1,400,858,889.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,362,415.3	883,686,395.2
210101	Үндсэн цалин	378,297,050.9	534,689,054.9
210102	Нэмэгдэл	198,939,658.4	288,466,125.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	25,212,765.2
210104	Урамшуулал	6,125,705.9	35,318,450.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,258,033.4	16,810,085.1
210205	Эрүүл мэндийн даатгал	11,258,033.4	16,810,085.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,751,468.4	107,214,554.6
210301	Гэрэл, цахилгаан	59,251,068.4	91,511,154.6
210302	Түлш, халаалт	13,430,400.0	14,703,400.0
210303	Цэвэр, бохир ус	1,070,000.0	1,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	20,778,561.8	21,038,050.0
210401	Бичиг хэрэг	856,000.0	1,300,000.0
210402	Тээвэр, шатахуун	17,785,000.0	18,070,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,466,961.8	1,000,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,500.0	33,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	637,100.0	634,550.0
2105	Нормативт зардал	110,153,900.0	153,372,600.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,550,700.0	8,130,000.0
210502	Хоол, хүнс	104,603,200.0	145,242,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,257,400.0	28,929,700.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	949,500.0	7,818,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	311,700.0	1,111,700.0
210604	Урсгал засвар	8,996,200.0	20,000,000.0
2107	Томиллолт, зочны зардал	180,000.0	0.0
210702	Дотоод албан томиллолт	180,000.0	0.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,796,160.4	183,475,600.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,984,960.4	177,207,000.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	252,100.0	1,008,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	715,200.0	300,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	129,500.0	80,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	588,300.0	4,554,500.0
210807	Газрын төлбөр	126,100.0	326,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,539,627.3	6,331,904.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,092,227.3	5,892,292.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	447,400.0	439,612.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,976,903.0	429,771,099.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,000,000.0	0.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	5,000,000.0	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,976,903.0	424,057,083.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	63,950,700.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	357,521,383.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,976,903.0	2,585,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	5,714,016.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	5,714,016.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,546,207.0	17,635,020.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.0	13,232,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	13,232,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	13,232,000.0
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	0.0	13,232,000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.0	-13,232,000.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,546,207.0	4,403,020.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,589,252.2	11,135,459.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,135,459.2	15,538,479.2

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,534,497.9	740,268,661.8	199,704,922.7	1,475,508,082.4
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	535,534,497.9	740,268,661.8	199,704,922.7	1,475,508,082.4
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(41,871,871.0)	(41,871,871.0)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,534,497.9	740,268,661.8	157,890,911.5	1,433,694,071.1
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,534,497.9	740,268,661.8	116,019,040.5	1,433,694,071.1
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(84,079.1)	(84,079.1)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	535,534,497.9	740,268,661.8	157,806,832.4	1,433,609,992.1
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	59,213,979.9	59,213,979.9
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,534,497.9	740,268,661.8	217,020,812.3	1,492,823,972.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,684,508,900.0	1,838,147,972.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,684,508,900.0	1,838,147,972.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,259,999,900.0	1,414,090,889.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	883,699,700.0	883,686,395.2
210101	Үндсэн цалин	509,321,000.0	534,689,054.9
210102	Нэмэгдэл	332,474,500.0	288,466,125.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,000,000.0	25,212,765.2
210104	Урамшуулал	13,904,200.0	35,318,450.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,572,000.0	16,810,085.1
210205	Эрүүл мэндийн даатгал	21,572,000.0	16,810,085.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,013,300.0	107,214,554.6
210301	Гэрэл, цахилгаан	93,309,900.0	91,511,154.6
210302	Тулш, халаалт	14,703,400.0	14,703,400.0
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.0	1,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,041,300.0	21,038,050.0
210401	Бичиг хэрэг	1,300,000.0	1,300,000.0
210402	Тээвэр, шатахуун	18,071,000.0	18,070,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.0	1,000,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,500.0	33,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	636,800.0	634,550.0
2105	Нормативт зардал	153,372,600.0	153,372,600.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,130,000.0	8,130,000.0
210502	Хоол, хүнс	145,242,600.0	145,242,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,161,700.0	42,161,700.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,050,000.0	21,050,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,111,700.0	1,111,700.0
210604	Урсгал засвар	20,000,000.0	20,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	445,400.0	0.0
210702	Дотоод албан томилолт	445,400.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,346,500.0	183,475,600.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,000,000.0	177,207,000.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	252,100.0	1,008,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.0	300,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.0	80,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,588,300.0	4,554,500.0
210807	Газрын төлбөр	126,100.0	326,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,347,400.0	6,331,904.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,900,000.0	5,892,292.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	447,400.0	439,612.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	424,509,000.0	424,057,083.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	424,509,000.0	424,057,083.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,950,700.0	63,950,700.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	357,521,500.0	357,521,383.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,036,800.0	2,585,000.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,684,508,900.0	1,853,979,024.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,684,508,900.0	1,635,637,016.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,684,508,900.0	1,635,637,016.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.0	218,342,008.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	218,342,008.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	11,135,459.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	15,538,479.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022 ОН	2023 ОН
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	1,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	800,000.00
210807	Газрын төлбөр	0.00	200,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих анги нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах, хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчдэд шуурхай үйлчлэх чиг үүрэг бүхий Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллага юм.

2023 оныг “Эрүү, иргэний, захиргаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд мэргэжлийн манлайлал, технологийн дэвшил, цахим шилжилтэд тулгуурлан нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглүүлэн үр дүнтэй зохион байгуулах” зорилго дэвшүүлэн 4 зорилт, 39 ажил, арга хэмжээг төлөвлөн ажилласан байна. Дэвшүүлсэн зорилго, зорилт, арга хэмжээг 99,5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих;
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар нэгдсэн тоо бүртгэл хөтлөх цахим сан бүрдүүлэх, лавлагаа мэдээлэл олгох
- Иргэний, зөрчлийн, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой журам, стандарт, заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд төлбөртэй этгээдийн бүртгэл, гүйцэтгэх баримт бичгийн тоо бүртгэл, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн цахим сан хөтлөх, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 151 дүгээр зүйл “Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааг эхлүүлэх”, 203 дугаар зүйл “Нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, түүний чиг үүрэг” болон Төсвийн тухай хуулийн зарим зүйл заалт тухайлбал 8 дугаар зүйл “Төсвийн цагалбар”, 23 дугаар зүйл “Төсвийн орлого”, 24 дүгээр зүйл “Төсвийн зарлага”, 27 дугаар зүйл “Төсвийн төсөлд тавигдах шаардлага”-д өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн а/13 дугаар “Дотоод хяналт шалгалт хийх ажлын хэсгийг байгуулах тухай” тушаалаар ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй томилж, дотоод хяналт шалгалт явуулах 2022 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсан байна. Ангийн даргын 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн “санхүүгийн албаны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх тухай” а/44 дүгээр

тушаалаар удирдамжийг баталж, хяналт шалгалтыг хийж ангийн даргад танилцуулдаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих анги нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хяналт шинжилгээ, үнэлгээ аудитын газар гүйцэтгэдэг байна. 2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд ШШГЕГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ аудитын газраас аудит хийгээгүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ШШГЕГ боловсруулан баталж үйл ажиллагаанд нь мөрдүүлэн ажиллаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 417 дугаар нээлттэй хорих анги нь ШШГЕГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,807.9 мянган төгрөгөөр буюу 4,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,135.5	15,538.5	4,403.0
Авлага	4,460.9	13,348.4	8,887.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	152,079.2	295,305.9	143,226.7
Үндсэн хөрөнгө	1,309,425.1	1,211,715.8	(97,709.3)
Нийт хөрөнгө	1,477,100.7	1,535,908.6	58,807.9
Өр төлбөр	43,406.6	43,084.7	(322.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,433,694.1	1,492,824.0	59,129.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,477,100.7	1,535,908.6	58,807.9

Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 2,912.0 мянган, эм боох материал 44.52 мянган, дуусаагүй үйлдвэрлэл 15,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бэлэн бүтээгдэхүүн 12,158.7 мянган, бичиг хэргийн материал 6,438.5 мянган, аж ахуйн материал 3,664.1 мянган, түлш шатахуун 1,531.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд машин тоног төхөөрөмж 30,976.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд хөрөнгө хасагдаагүй байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 13,232.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 17,744.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө нэмэгдэхэд ШШГЕГ-аас CG-10, CG-7 загварын уурын зуух шилжүүлсэн өгсөн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,393,664.0 мянган, туслах үйл ажиллагааны орлогоос 126,544.6 мянган, нийт зарлагыг 1,520,208.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 1,018,707.3 мянган, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардлыг 19,120.0 мянган, бусад нийтлэг АУТХ-ийн зардлыг 126,544.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

2023 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмж 63,950.7 мянган төгрөгийн нэмж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,684,508.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,628,923.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 218,342.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,623,489.3 мянган төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг байр ашиглалттай холбоотой зардал 1,798.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 5,492.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,204,414.00	1,199,432.24	4,981.76	99.6
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-Туслах үйл ажиллагааны зардал	55,585.90	53,727.93	1,857.97	96.7
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	424,509.00	424,057.08	451.92	99.9
	Дүн	1,684,508.90	1,677,217.25	7,291.65	99.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд уулзалт эргэлтийн орлого 1,000.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Нэмэлт санхүүжилтийн орлогоос аудитын үйлчилгээний төлбөрт 800.0 мянган төгрөг, газрын төлбөрт 200.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70705 /Шүүхийн шийдвэр гүйцэтгэл/- 80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, учирсан хохирлыг барагдуулах, хүний хөгжлийг дэмжсэн үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгон бүтээн байгуулалтыг дэмжих, хүний эрхэд суурилсан хандалгыг төлөвлүүлэх 4 зорилт, 39 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх	Хоригдол нарыг ажлын байраар хангаж, авсан цалин, орсон орлогоос учирсан хохирлыг барагдуулах, нийгэмшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж байна.	1,204,414.00	1,199,432.24
2	70705 /Шүүхийн шийдвэр гүйцэтгэл/- 80102 /Туслах үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	Туслах үйл ажиллагаа болох цайны газар, дэлгүүр, ойжуулалт, мод бэлтгэл, модон эдлэл, мал аж ахуй эрхлэх	Туслах эрхлэхэд цалингийн зардалд 17,901.4 мянган төгрөг, ашиглалт, бараа үйлчилгээний зардалд 35,5461.9 мянган төгрөг зарцуулж 53,727.9 мянган төгрөгийн орлого орсон байна.	55,585.90	53,727.93
3	70705 /Шүүхийн шийдвэр гүйцэтгэл/- 80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2023.01.01 2023.12.31	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид болон хөдөлмөрийн дотоод журамд заасан өхцөл байдалд олгох	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад 357,521.4 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжид 63,950.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 2,133.1 мянган төгрөг олгосон байна. Хэрэгжилт 100 хувь	424,509.00	424,057.08
Дүн					1,684,508.90	1,684,508.90

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг 99,9 хувьтай хийж гүйцэтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих анги 2023 онд шатахуун 14,703.4 мянган төгрөг, хоол хүнсний материал 145,242.6 мянган төгрөг, багаж, техник хэрэгсэл 7,818.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ 28,156.8 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 982,086.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 14,731.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,311.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ШШГЕГ-ын харьяа нээлттэй 417 дугаар хорих ангийн 2023 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийхэд ажил гүйцэтгэх болон ачаа тээвэрлэлтийн гэрээг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн НББ, дотоод хяналттай 2 албан шаардлага, 2 зөвлөмж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн №01/403 дугаарын албан бичгээр Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	5,009.1	2	5,009.1	100
Зөвлөмж	3	259,603.7	3	259,603.7	100
Нийт дүн	5	264,612.8	5	264,612.8	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл болон үндсэн хөрөнгийн орлого /гэр/-ыг авч үзэхээр шийдвэрлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,000.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 15,000.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Бараа материалын орлогын журналд дуусаагүй үйлдвэрлэлийн орлого, зарлагыг 15,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 13,315.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 13,315.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

1. Төсвийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 13,315.2 мянган төгрөгийн төхөөрөмж, бараа материал худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын “Зардлын эдийн засгийн заавар ашиглах журам” болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөн ажиллаж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах боломжтой бол дахин үнэлэх, боломжгүй бол эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 03 сарын 25-ны дотор, хэрэгжилтийг 2024 оны 06 сарын 25-ны дотод Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	
							Тоо	Дүн
Бараа материалын орлогын журналд дуусаагүй үйлдвэрлэлийн орлого, зарлагыг зөрүүтэй тайлагнасан.	1	15,000.0			1	15,000.0	1	15,000.00
Дүн	1	15,000.0	0	0.0	1	15,000.0	1	15,000.00

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1						1			
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас төхөөрөмж, бараа материал худалдан авсан байна.	1	13.315.2					1	13.315.2		
Дүн	2	13.315.2					2	13.315.2		

